

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**ТАНЗАНИЙ НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН
ХӨГЖИЛ****Э. Эрдэнэчимэг**

Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний гол амжилт бол империализмын колонийн тогтолцоог эвдэж, үндэсний шинэ залуу улсууд үүсч, тэдний зарим нь социалист чиг баримжаагаар улс орноо хөгжүүлж, эдийн засгийн тусгаар тогтнолыг хангах үйлст зориг төгөлдөр орсон явдал болно. Ийнхүү социалист чиг баримжаагаар хөгжиж буй африкийн орнуудын нэг Бүгд Найрамдах Нэгдсэн Танзани Улс (БННТУ) юм. 1964 оны дөрөвдүгээр сарын 26-нд Танганик Улс зэргэлдээ арал дээр орших Занзибар ба Пембийн улстай сайн дур, тэгш эрхийн үндсэн дээр нэгдэж БННТУ байгуулагдсан.*

Джулиус Ньерере тэргүүтэй хувьсгалт ардчилсан үзэлтнүүдийн хүчин зонхилж байгаа Танганикийн Африкийн Үндэсний Холбоо (ТАҮХ) нам 1954 онд байгуулагдсан үеэс эхлэн империалист колоничлолын эсрэг танзаний ард түмний тэмцлийг дэмжив. ТАҮХ нам колоничлолын засаг захиргаа түүнийг дэмжигч хүч улс төрийн хагалан бутаргагч хүч, тус намын дотор байсан «зүүний» болон барууны урсгалуудын эсрэг тэмцэж иржээ.

БННТУ үндэсний тусгаар тогтнолоо олсноос хойшхи хугацаанд нийгэм-эдийн засгийн өөрчлөлтийг амжилттай өрнүүлж ирсэн нь капиталист биш хөгжлийн замыг сонгон авсны үр дүн юм.

Капиталист биш хөгжлийн шатанд дэвшсэн улс орны өмнө нийгэм- эдийн засгийн өөрчлөлтийг алхам алхмаар гүнзгийрүүлж хөдөө аж ахуйг хоршоолон, үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэн, эдийн засгийн тусгаар тогтнолд улам бүр ойртон, ард түмний аж байдлыг сайжруулж, соёлын хэмжээг дээшлүүлэх төрийг жолоодох үйлст хөдөлмөрчдийг улам идэвхтэй оролцуулж, төрийн ардчиллыг хэлбэрэлтгүй өргөтгөх зэрэг бодит ахицаар капиталист биш хөгжлийг бататгаж эцсийн зорилгод хүргэж болох юм.

Капиталист биш хөгжил нь шинжлэх ухааны социализмгүйгээр утга чанараа алдах бөгөөд социализмд хүрэх явдалд л капиталист биш хөгжлийн замын утга, чанар нь оршиж байна.

60-аад оны эхэн үед Танзанийн ерөнхийлөгч Дж. Ньеререгийн баримталж байсан «Африкийн социализм» гэгч онол нь шинжлэх ухааны социализмаас онол, практикийн хувьд хол байсан бол сүүлдээ энэ онолын хуучирсныг ойлгож ихээхэн өөрчлөлт оруулсан бөгөөд 1965 оны Үндсэн хууль, 1967 оны Арушийн тунхаглалд социалист үзэл санааг улам гүнзгий тусгаж шинжлэх ухааны социализмд алхам алхамаар ойртон нийлэх хандлагаар явж байна.

* 1961 оны арван хоёрдугаар сарын 9-нд Танганик. 1964 оны нэгдүгээр сарын 12-нд Занзибар тусгаар тогтнолоо тунхагласан.

БННТУ нь Баруун Африкт оршдог. 945,1 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, 18.5 сая (1982) хүн амтай, Нийслэл нь Дар-эс-Салам (157 мянган оршин суугчтай).

ТАҮХ намын программын үндсэн баримт бичиг нь 1967 оны гуравдугаар сард ТАҮХ намын онц бага хурлаар баталсан Арушийн* тунхаглагч юм. Энэ тунхаглалд намын гол зорилго бол социалист төр байгуулж, хүн хүнээ дарлан мөлжих явдлыг устгаж, тус орны тусгаар тогтнолыг бэхжүүлэх явдал¹ гэж заажээ.

Тунхаглалд социализмыг байгуулан бэхжүүлэхийн тулд улсын болон хоршоолсон байгууллагуудын шууд хяналтын дор үйлдвэрлэлийн үндсэн хэрэгслийг аажмаар шилжүүлэх чиг шугамыг дэвшүүлжээ. Ингээд тавьсан зорилгодоо хүрэх зам бол өөрийн хүчинд тулгуурлах явдал юм² гэж дурьджээ.

Тэхдээ африкийн удирдагчдын дэвшүүлж буй «өөрийн хүчинд тулгуурлах» гэсэн онол нь гол утгаараа бол хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэхийн үүднээс эд агуурсын болон хүн хүчний нөөцийг өргөн ашиглах, империалист гүрнүүдээс хараат бус үндэсний эдийн засгийг байгуулах, шинэ колоничлолын эсрэг тэмцэх явдал юм³.

БННТУ бол Африкт нэг намын системтэй улсын тоонд орж байгаа бөгөөд 1965 оны долдугаар сарын 10-нд баталсан БННТУ-ын түр үндсэн хуульд тус орныг удирдан чиглүүлэх албан ёсны ганц нам бол ТАҮХ нам мөн гэж дурьджээ. Энэ талаар ч тус улсын ерөнхийлөгч Дж. Ньерере мэдэгдэхдээ: «Танзанийн ард түмэн ганцхан намыг хүлээн зөвшөөрөх бөгөөд тус улсын үндсэн хуульд ч ганц намыг л хүлээн зөвшөөрнө»⁴ гэжээ.

ТАҮХ намын удирдах эрх, үүргийг тус орны амьдралын бүх салбарт бэхжүүлэх нь чухал гэж Арушийн тунхаглалд онцлон тэмдэглэснээс гадна социализм байгуулахын тулд ТАҮХ намын удирдлагаар нийгмийн гүн гүнзгий өөрчлөлт хийж, эдийн засагт ноёрхогч колоничлолыг устгах, үгүйрэл, хоцрогдлыг арилгах, хөдөө аж ахуйг хөгжүүлэх явдал чухал юм. Хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд «Уджамаа»* тосгоныг байгуулах нь чухал гэж үзжээ.

Танзани улс бол байгалийн баялаг ихтэй газар тариалан эрхэлсэн, хөдөө аж ахуйн орон учир хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд «Уджамаа» тосгон байгуулах явдал гол үүрэг гүйцэтгэж иржээ. Засгийн газрын дэмжлэгээр шинэ шинэ тосгодуудыг тариачдын сайн дурын үндсэн дээр байгуулан хамтарч амьдрах, ажиллах үйл хэргийг зохион байгуулах болон үйлдвэрлэлд машин техник нэвтрүүлэх зэрэг гурван үндсэн зорилготой ажиллаж иржээ.

1967 оны эцсээр «Уджамаа» тосгон 180 байсан бол 1968 онд 360, 1969 онд 671, 1970 оны эцэст 1828 болж 500 мянган тариачдыг хамарч байсан⁵ бол 1981 онд 13 сая хүн, 8000 тосгон хамрагдах болжээ.⁶ Эхний үед тосгон нэг бүрт 25—70 айл өрх багтаж, гишүүн бүрд 0,4 талбай ноогдож байсан байна. Тосгоны харьяа дэвсгэрийг тохижуулах,

*Аруш хот бол Танзанийн хойт хэсэгт байх бөгөөд уг тунхаглалыг энэ хотод зохиосон учир тийнхүү нэрлэжээ.

¹ La Declaration d'Arucha ou le TANU et sa politique socialiste d'indépendance. Paris. 1970, p. 79.

² Мөн тэнд.

³ В. Г. Солодовников. Проблемы современной Африки. М., 1973. с. 197

⁴ В. Я. Кацман. Современная Танзания М., 1977, с. 16.

* «Уджамаа» гэдэг нь нийт хүмүүсийн сайн сайхны төлөө хамтаар амьдарч, хамтран ажиллах нэгдэл гэсэн утгатай үг юм.

⁵ В. Я. Кацман. Современная Танзания. М., 1977, с. 121

⁶ Жигунов. И. Николаевский. Приоритет сельскому хозяйству, — «Азия и Африка сегодня» 1983, № 1, с. 47.

гүүр зам тавих, орон сууц, сургууль соёлын газрууд, эмнэлэг, холбоо захиргааны барилга байгууламжийг хамтын хүчээр барьж байна.⁷

Африкийн хөгжиж байгаа орнуудад газар зээмшил ба эдэлбэрийн хэлбэр өөр өөр байгаа бөгөөд харин танзанид «уджамаа» тосгон байгуулснаар хүй нэгдлийн аж ахуйг орчин үеийн хоршооллын аж ахуй болгон социалист чиглэлд оруулах туршлага анх үүссэн байна.

«Уджамаа» тосгон байгуулах бодлого бол үндэсний онцгой шинж чанартай юм. Энэ нь социалист чиг баримжааг сонгон авсан явдал нь нийгэм-эдийн засгийн хоцрогдлыг арилгах, хөдөө аж ахуйд орчин үеийн үйлдвэрлэлийг нэвтрүүлэх бололцоог олгож буйг харуулж байгаа юм. Гэхдээ энэ бүгдийг тийм амар хийх зүйл бишээ.

В. И. Ленин: «тариачны хувийн жижиг аж ахуйгаас газрыг нийгмээр боловсруулахад шилжих шилжилт, ийм маягийн эргэлт удаан хугацаа шаардана. Үүнийг дав даруйхан хийчихэж яасан ч болохгүй нь аяндаа илэрхий байна. Жижиг тариачны аж ахуйтай орнуудад аажмаар урьдчилан туулах хэд хэдэн шатыг дамжихгүйгээр социализмд шилжин орж болохгүй гэдгийг бид сайн мэдэж байна»⁸ гэсэн билээ.

Танзаний засгийн газар тариачдын дунд хэвшсэн олон жилийн феодалын уламжлалыг арилгах, ангийн дайсны элдэв эсэргүүцлийг дарах зэрэг бэрхшээлүүдтэй тулгарч байсан боловч түүнийг амжилттай давж ирлээ.

Эдийн засгийн тусгаар тогтнолыг хангах асуудал нь үндэсний эдийн засгийн олон салбарын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан аж үйлдвэржих зорилгыг шийдвэрлэх, үйлдвэрт хөдөө аж ахуйн харилцан үйлчлэх үйл ажиллагааг зохицуулах, эдгээрийн аль алиныг үйлчлэх түлш эрчим хүчний зэрэг салбарын хөгжлийг тохируулах, байгалийн нөөцийн боломжийг ашиглах, хэтийн зорилготой уялдуулан дэс дараатай үйлдвэрлэх хүчний байршилтыг боловсруулах, гадаад, дотоод зах зээлийн багтаамжийг өргөтгөх эдгээр асуудалтай уялдуулан мэргэжлийн боловсон хүчнийг ээлж дараатай бэлтгэх зэрэг нэгдмэл үйл ажиллагааны үр дүнд шийдвэрлэгдэх билээ.⁹

Танзани улс 1961—1963 онд эдийн засгийн үндсийг тавих гурван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж гадаадын хөрөнгөтний мэдлийн үйлдвэрүүдийг улсын болгож, хөдөө аж ахуйг хоршоолох, төлөвлөгөөжүүлэх зэрэг арга хэмжээ авчээ. 1964 оноос гурван таван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ирэв. Хоёрдугаар таван жилийн төлөвлөгөөг Арушийн тунхаглалд үндэслэсэн бөгөөд энэ нь эдийн засагт хөдөө аж ахуйн салбарыг голчлон хөгжүүлэх зорилготой байв. Гуравдугаар таван жилийн төлөвлөгөөнд улс орныг аж үйлдвэржүүлэх, хэрэгцээт барааны үйлдвэрийг хөгжүүлэх экспортод гаргах байгалийн баялгийг өөрсдөө боловсруулах, хөдөө аж ахуйн хөдөлмөрийн багаж зэмсэг, барилгын материал үйлдвэрлэх явдлыг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна.

60-аад оны хоёрдугаар хагаст 569 үйлдвэртэй болсны дотор нэхмэл, гутал, хувцас, арьс шир зэрэг үйлдвэрүүд орж байна.¹⁰

1968 онд Танзани Замбийн хооронд нефть дамжуулах хоолойг байгуулснаас гадна жилд 10 мянган тонн ган хайлуулах үйлдвэрийг ашиглалтад оруулжээ. Энэ нь юуны өмнө эдийн засгийн тусгаар тогтнолыг

⁷ В. В. Павлова. Танзания: планы созидания—«Азия и Африка сегодня», 1981. № 5, с. 25.

⁸ В. И. Ленин. ПСС т. 37. с. 356.

⁹ Н. Дангаасүрэн «Гурав дахь ертөнц»: эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал. УБ., 1977 он, 68-р тал.

¹⁰ В. В. Павлова Танзания: экономическая политика правительства. М., 1973. с. 161.

хангах чадвар бүхий аж үйлдвэрийг байгуулахын тулд хөнгөн, хүнс, олзворлох үйлдвэрийн салбарыг эхлэн хөгжүүлж улмаар үйлдвэрийн хэрэгслийн үйлдвэрийг тус оронд бий болгох талаар чухал алхам хийсний баталгаа юм.

Эдийн засгийн тусгаар тогтнолыг хангахын тулд засгийн газраас улсын секторыг бэхжүүлэх арга хэмжээ авсны үр дүнд санхүүг 100 хувь, олзворлох үйлдвэрийн 70 хувь, боловсруулах үйлдвэрийн 40 хувь, тээврийн 55 хувийг улсын мэдэлд авсан байна.¹¹

Улс орныг үйлдвэржүүлэх явцад хүн амыг өдөр тутмын хэрэгцээт бараагаар хангаж, хөвөн бөс бараа, бэлэн хувцас, гэр ахуйн хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх болжээ.

Нийгэм эдийн засгийн гүнзгий өөрчлөлт хийх, улс орноо үйлдвэржүүлэхэд дотоодын нөөц баялгийг дээд хэмжээгээр ашиглаж, орлогын эх булгийг арвижуулах нь чухал юм. Иймд 1967 онд Сизалийн* 6 том пүүсийг улсын мэдэлд авч, сизаль үйлдвэрлэлтийн 50-иас дээш хувийг гаргаж байна. Танзанийн «ногоон алт» хэмээн нэрлэгддэг хөдөө аж ахуйн үндсэн гол бүтээгдэхүүн болох сизаль тариалалтыг улам нэмэгдүүлэх зорилт тавьж, 1985 он гэхэд 110 мянган гектар талбайд сизаль тариалах буюу одоогийн хэмжээнээс 2 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөжээ.¹²

Гэвч байгалийн бэрхшээлээс шалтгаалж ургац авахгүй байх тохиолдол гардаг нь тус улсын эдийн засагт нэмэгдэл бэрхшээл учруулж байна. Африкийн хүн амын өсөлт улам бүр нэмэгдэж, хүнсний бүтээгдэхүүнээр хүн амын хэрэгцээг хангах асуудал хурц тавигджээ. Танзанийн засгийн газар ч энэ талаар тодорхой арга хэмжээ авч байна. 1980 онд тус улсын хүн амыг хүнсээр хангах боломжийг нэмэгдүүлэх, улс орноо үр тариа, мал аж ахуйн бүтээгдэхүүнээр хангах зорилт тавьж, 1985 он хүртэл хөдөө аж ахуйд 21,4 сая долларын хөрөнгө оруулахаар төлөвлөжээ.¹³

Хөдөө аж ахуйн хөгжлийг түргэтгэх чухал нөхцлийн нэг бол хөдөө аж ахуйг орчин үеийн усжуулах барилга байгууламж, эрчим хүчээр хангах асуудлыг шийдвэрлэх явдал юм. Энэ талаар ч тус улсын засгийн газар эдийн засгийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан арга хэмжээ авсны үр дүнд 1961—1971 онд 380 сая квт цагийн хүчин чадалтай хэд хэдэн усан цахилгаан станц байгуулснаар одоо 612 сая квт цагийн цахилгаан гаргаж байна.

1970 онд тус улсын эдийн засагт үндэсний орлогын 81 хувийг хөдөө аж ахуй, 10,6 хувийг загас агнуур, 2,9 хувийг аж үйлдвэр, 2,8 хувийг тээвэр, худалдаа оруулж байв.¹⁴

¹¹ В. Я. Кацман. Современная Танзания. М., 1977, с. 139.

*Сизаль гэдэг нь агав модны мөчрөөс гаргах нэхмэлийн олс, XIX зууны эцсээр германы колоничлогчид уг ургамлыг төв Америкаас авчирч суулгасан бөгөөд сизаль тариалалтаар одоо дэлхийн 1-рт орж байна.

¹² А. Жигунов. И. Николасвский Танзания приоритет-сельскому хозяйству— «Азия и Африка сегодня» 1983. № 1, е. 47.

¹³ Мөн тэнд.

¹⁴ В. В. Павлова Танзания: экономическая политика правительств М., 1973, с. 165.

*Мөнгөний нэгж шиллинг. 8,24 шиллинг 1 доллартай тэнцэнэ.

¹⁵ Хөрөнгөтний бус хөгжлийн замаар замнаж буй Ази Африкийн зарим орон. УБ. 1970, 76-р тал.

Танзанийн гурван удаагийн таван жилийн төлөвлөгөөний үр дүнд хүн амд ноогдох жилийн орлого нь 1961 онд 19,6 фонд стерлинг байсан бол 1980 онд 45,1 фонд стерлинг болж өсөх юм.¹⁵

Гадаад худалдаа 1961—1973 онд бараг 3 дахин өсч¹⁶ гадаадад гаргах бараа 973—2074 сая шиллин*г гадаадаас авах бараа 794—3080 сая шиллингэд хүрсэн байна.¹⁷ Сүүлийн хоёр жилд гадаадаас авах барааны хэмжээ гадаадад гаргах барааны хэмжээнээс 2 дахин өссөн байна. 60-аад оны үед гадаадад гаргадаг гол бараа нь сизаль, лиш цэцэг байсан бол 70-аад оноос кофе, хөвөн, сизаль, алмааз, самар, тамхи, цай зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гаргаж, гадаадаас техник, тоног төхөөрөмж, нефть, нефтийн бүтээгдэхүүн, өргөн хэрэгцээний бараа авч байна.

Аж үйлдвэрийг хөгжүүлэх үйл явц нь зөвхөн эдийн засгийн асуудал биш нийгмийн шинэчлэн байгуулалтын амин чухал асуудал учраас орчин үеийн үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн явцад ажилчин ангийн эгнээ өсөөд зогсохгүй улс төрийн ухамсартай зохион байгуулалттай хүчин болж байна.

Африкийн бусад орнуудыг бодвол Танзанид ажилчин ангийн эгнээ харьцангуй цөөн байгаа бөгөөд үүний дотор орчин үеийн үйлдвэрийн ажилчид бүр ч бага суурь эзэлж байна. 1961 онд 412 мянган ажилчин байсан бол 1973 онд 450 мянга болон өсчээ.¹⁸ 60-аад оны дундуур тариалангийн талбайд ажиллагсадын тоо цөөрчээ. 1970-аад оны үед улсын секторт ажиллагсад эрс өссөн байна.

Статистикийн мэдээгээр загас агнуурын аж ахуй, ойн аж ахуй, хөдөө аж ахуй зэрэгт ажиллагсад 1965 онд 234 мянга, 1967 онд 239 мянга, 1971 онд 261,7 мянга болжээ.¹⁹

1962—1964 онд Заир, Мозамбик, Руанда, Бурундигаас ирдэг хөлсний ажилчид 37,2 мянга байснаа 29,3 мянга болж хорогджээ.²⁰

Тус орны өмнө тулгарч байсан том асуудлын нэг бол ажиллах хүчнийг зөв зохистой хуваарилах, тэдний мэргэжил чадварыг дээшлүүлэн хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх явдал байв. Танзанид колоничлолын уршгаас болж аж ахуйн олон салбарыг хөгжүүлэхэд элдэв саад бэрхшээл тулгарч, ажилгүйдэх явдал гарч байв. Иймээс засгийн газар ажилгүйдэлтэй шийдвэртэй тэмцэж байна. Хөдөөнөөс хотод шилжигсэдийг цөөлөхийн тулд хөдөөд ажлын орон тоог нэмэгдүүлэх материаллаг сонирхлыг дээшлүүлэх, хөдөө аж ахуйн суурин газруудыг тохижуулах, залуучуудыг хөдөөд суурьшуулах, соёл ахуйн хангамжийг эрс сайжруулах чиг шугамыг хэрэгжүүлж эхэлжээ. 1964 онд Дар-эс-Салам, Танге зэрэг хотод 1300-гаад ажилгүйчүүд байсны 161 нь сизалийн талбайд ажиллах болжээ.²¹

Арушийн тунхаглалд тус оронд соёлын хувьсгалыг өрнүүлэх зарчмийг зааснаас хойш энэ талаар чухал өөрчлөлт гаргав. Үүний үндсэн дээр бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах, бүх нийтэд анхны боловсрол олгох, дээд сургуулиуд байгуулах, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх ажлыг амжилттай шийдвэрлэж байна. 1980 онд бүх хүн амын

¹⁶ В. В. Павлова. Танзания: экономическая политика правительства. М., 1973, с. 165.

¹⁷ В. Я. Кацман. Современная Танзания. М., 1977, с. 138.

¹⁸ В. Я. Кацман. Современная Танзания. М., 1977, с. 80

¹⁹ В. Мөн тэнд. с. 81.

²⁰ В. Е. Овчинников. Национальный союз африканцев Танганьики. М., 1967, с- 89.

²¹ Ю. Я. Кацман. Современная Танзания, М., 1977. с. 80.

20—80 хувь нь бичиг үсэгт тайлагдаж, бүх нийтэд анхны боловсрол олгох асуудлыг шийдвэрлэж, дунд ба дээд сургуульд суралцагчид 3 дахин өсчээ.²² 1961 онд 3100 бага сургууль 486 мянган сурагчидтай байсан бол 1971 онд 4705 сургуульд 848 мянган сурагчидтай болсон байна.²³ 1962 онд дээд, дунд боловсролтой хүн маш цөөн байжээ. Тухайлбал 16 инженер, малын эмч, 2, 2 химич, 2 геологич, 5 ойн мэргэжилтэнтэй байсан бол одоо мэргэжилтэй боловсон хүчний тоо нэмэгдэж, дотооддоо дээд сургуультай болсон байна. 1931 онд Дар-эс-Саламд анхны дээд сургууль нээгдсэн байна. 1966 онд болсон дээд сургуулиудын олон улсын чуулган дээр Дж. Ньерре «Шинэ тулгар орнуудын хөгжилд дээд сургуулийн гүйцэтгэх үүрэг» гэсэн илтгэл тавьж, дээд сургуулийг улам өргөжүүлж, түүнийг үзэл суртал, шинжлэх ухааны төв болгохын чухлыг тэмдэглэжээ.

1970 оны долдугаар сард Дар-эс-Саламын дээд сургуулийг Танзанийн үндсэн их сургууль болгон өөрчлөв. Энэ их сургууль нь хууль цааз, хөдөө аж ахуй, анагаах ухаан, инженер, нийгмийн ухааны факультеттэй байна.

Африкийн орнуудад өндөр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд ЗХУ үлэмж тусламж дэмжлэг үзүүлж байна. 1973 онд ЗХУ-д Ази, Африкийн 7000 оюутан суралцаж мэргэжлийн диплом авсны 150 нь Танзанийн оюутнууд байлаа.²⁴

Танзаний нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх нэг, хоёрдугаар таван жилийнхээ төлөвлөгөөнд эрүүлийг хамгаалах системийг хөгжүүлэх, эмнэлгийн ажилтныг бэлтгэх, эмнэлгийн газар, клиник, диспансер барьж байгуулах талаар төлөвлөжээ. Анхдугаар таван жилд «хөдөө дэх эрүүл ахуйн төвийн» барилга байгууламжийн төслийг оруулжээ.

1963 онд Дар-эс-Саламд эмч нарыг бэлтгэх сургуулийг нээж, 1968 онд энэ сургууль нь дээд сургуулийн нэг факультет болж анхныхаа жилд 30—40 эмчийг бэлтгэн гаргасан байна. Одоо жилд 100 гаруй эмч бэлтгэн гаргаж байна.²⁵ Мөн эмнэлгийн асрагч сувилагч эх баригчдын курс байгуулагдан ажиллаж байна. Эмнэлгийн тоо 1971 онд 10 жилийн өмнөхөөс 98—122 болтлоо өсч, эмнэлгийн төв 22—90, хөдөө дэх диспансер 975—1400 болсон байна.²⁶ Түүнээс гадна эмнэлгийн газруудыг шинэ тоног төхөөрөмжөөр тоноглож, 1964 оноос иргэдийг үнэ төлбөргүй эмчлэх заавар гаргасан байна.

Хөдөлмөрчдийн аж байдлыг сайжруулах явдалд үлэмж анхаарал тавьж, 1961 онд засгийн газраас улсын байгууллагад ажилладаг хүмүүст тэтгэвэр олгох систем тогтоосон байна. Эмэгтэйчүүдийн талаар их анхаарч эмнэлгийн үйлчилгээгээр хангах, түүнийг сайжруулах арга хэмжээ авч явуулжээ.

БННТУ гагцхүү социалист чиг баримжаагаар хөгжсөний үр дүнд хөдөө аж ахуй, үйлдвэрлэх хүчний хөгжлийг хурдатгаж, хоцрогдлыг арилгах, ард түмний аж амьдрал, соёлын хэмжээг дээшлүүлэх зэрэг нийгэм-эдийн засгийн хөгжлийг хангах явдлыг амжилттай шийдвэрлэж байна. Танзаний нийгэм-эдийн засгийн хөгжил дэвшилтэд ЗСБНХУ болои социалист хамтын нөхөрлөлийн орнууд үлэмж их тус дэмжлэг үзүүлж байна. БННТУ социалист орнуудтай, тогтоосон найрамдалт харилцаагаа хөгжүүлэн, олон улсын тайзан дээр төвийг сахих бодлого баримтлан

²² В. В Павлова Танзания планы созидания.—«Азия и Африка сегодня» 1981. № 5. с. 25.

²³ Африка проблемы социалистической ориентации. М.. 1976 с. 397.

²⁴ СССР и Африка. М., 1970, с. 361.

²⁵ В. Я. Кацман. Современная Танзания. М.. 1977, с. 54.

²⁶ В. Я. Кацман. Современная Танзания. М., 1977. с. 143

цэрэг улс төрийн ямар нэг эвсэлд үл нэгдэх, нийгмийн янз бүрийн байгуулалтай орнуудтай энх тайвнаар зэрэгцэн орших бодлого явуулж байна.

ОБЩЕСТВЕННО-ЭКОНОМИЧЕСКИЕ ПРЕОБРАЗОВАНИЯ В ТАНЗАНИИ.

(Р е з ю м е)

Распад колониальной системы и появление многих независимых государств в Африке в 60-е годы, усиление международного политического и экономического влияния социалистических стран и преимущества социализма обеспечили выбор некоторыми африканскими государствами некапиталистического пути развития. Среди стран, избравших социалистическую ориентацию, прочное место занимает Объединенная Республика Танзания.

С принятием в 1965 году первой конституции и в 1967 году Арушской декларации Танзания взяла курс на осуществление некоторых социально-экономических перемен: ликвидацию остатков колониализма, развитие национальной промышленности и преобразования в сельском хозяйстве. Первые шаги в этом направлении были сделаны с образованием первичных кооперативов-деревень-уджамаа, создаваемых при поддержке государства. Практика создания подобных деревенько оперативов стала примером для многих развивающихся африканских стран в эффективном преодолении феодальной и колониальной отсталости.

С 1964 года экономика Танзании развивается по пятилетним планам, III-пятилетний план предусматривал развитие национальной индустрии, увеличение производства сельскохозяйственной продукции, орудий труда и стройматериалов, обеспечение населения продуктами первой необходимости.

С укреплением государственного сектора выросла внешняя торговля Танзании, появились новые статьи экспорта, стабилизировался внутренний рынок.

Развитие систем общеобразовательных, начальных школ и образование в 1970 г. национального университета в Дар-эс-Саламе позволяет в короткие сроки подойти к решению проблемы обеспечения страны национальными кадрами.

Социалистическая ориентация, избранная Танзанией, благоприятствует ускоренному прогрессу в сельском хозяйстве, развитию производительных сил, ликвидации отсталости и неграмотности, повышению жизненного и культурного уровня населения, проведению широкого спектра социально-экономических реформ.

Советский Союз и страны социализма оказывают всестороннюю поддержку этому молодому африканскому государству. В развитии дружественных отношений с социалистическими странами руководство ТАНУ видит перспективу дальнейшего развития народного хозяйства.